



Баримт бичгийн нэр	“УЛААН ХАСЫН” УУРХАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
Гүйцэтгэгч	“Өмнийн говийн баялаг” ХХК
Төслийн нэр	Баялаг нэртэй “Улаан хас” чулууны уурхай (MV-021252)
Огноо	03/12/2025
Төлөвлөгөөний биелэлт боловсруулсан	Ц.Отгонбат /Байгаль орчны мэргэжилтэн/
Хянасан	Д.Ариунболд /Байгаль орчин хариуцсан зөвлөх/
Баталсан	Д.Бандихүү / “Өмнийн говийн баялаг” ХХК-ийн Гүйцэтгэх захирал/
Хүлээн авагч хуулийн этгээд	Өмнөговь аймгийн Байгаль орчны газар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
Хувийг	Өмнөговь аймгийн Гурвантэс сумын ЗДТГ



ГАРЧИГ


ГАРЧИГ.....	2
1. ТӨСЛИЙН БОЛОН ТУХАЙН ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
Төслийн товч мэдээлэл	3
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	4
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	6
4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	8
5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	9
6.ТҮҮХ, СОЁЛЫГ ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	10
7.ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	13
8.ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	13
9.ОРЧНЫ ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	14
10. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ.....	16
11.БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
12.БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРИЙН БИЕЛЭЛТ	18
ХАВСРАЛТ	19

1. ТӨСЛИЙН БОЛОН ТУХАЙН ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн товч мэдээлэл

“Улаан хас” чулууны уурхайд ашиглалт явуулж буй “Өмнийн говийн баялаг” ХХК нь (улсын бүртгэлийн дугаар: 1111008068) орон нутгийн харъяалалтай Монгол улсад гоёл чимэглэл болон өнгөлгөөний чулууны хайгуулаар 2 жил, олборлолтоор 1 дахь жилдээ ажиллаж байна.

“Гүн” нэртэй уурхай нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэр V буюу Бага Овоо багийн нутагт, Хөвхийн хөндийн хойд уулархаг хэсэгт Шөгшөө уулын баруун өвөрт, Даланзадгад хотоос 320 км, нийслэл Улаанбаатар хотоос 950 км зайд, баруун өмнөд зүгт, Шивээ-Хүрэнгийн боомтоос 76 км-т (х.ө 43°12'260, з.у 101°10'42, өндөршил д.т.д 1626 метр) оршдог. Тусгай зөвшөөрлийн дугаар MV-021252 (49.28 га) ба 2048.12.28-ны өдрийг дуустал тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа үйлчилж байна.



Зураг 1. Гүнгийн уурхайн байршил

“Гүн” нэртэй ордын үндсэн ашигт малтмал нь сул цементлэгдсэн конгломератад агуулагдах улаан хас байх ба ордын хэмжээнд нийт нөөцийн дунджаар 4.6% нь улаан хас байна. Дагалдах ашигт малтмал болох хас агуулсан конгломерат буюу хайрганы хэмжээ нь ордын нийт нөөцийн үлдсэн хэсэг буюу 95.4% байна. Улаан хасын ордын хас агуулсан конгломерат нь ордын нийт талбайн хэмжээнд тархсан ба хас агуулсан конгломератын зузаан нь 5,0-20,0м-т хэлбэлзэх ба дунджаар 15,0м байна.

Улаан хасыг Шивээ хүрэнгийн боомтоор БНХАУ руу экспортлох бөгөөд гол хэрэглэгч нь Хятадын барилга болон гоёл чимэглэл хийдэг үйлдвэрүүд юм. “Гүн” нэртэй сул цементлэгдсэн конгломератад агуулагдах улаан хасын ордын зүүн хойд хэсгийн анх батлагдсан геологийн нийт нөөц нь В+С зэрэглэлээр, хайргаар 579200.7 м³ буюу 1’332.161.6 тн, улаан хасын нөөцтэй.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН-2025 ОН



Хүснэгт 1. Тухайн оны гүйцэтгэлийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	Өмнийн говийн баялаг ХХК
Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	1111008068 (Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар)
Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Гадаад худалдаа, Ашигтмалтын хайгуул хийх, Ашигт малтмалын ашиглалт
Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг	Бага Овоо 5-р баг, Гурвантэс сум, Өмнөговь аймаг, Монгол Улс, Утас: 976-99998819, 88030030
Захиралын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Д.Бандихүү; 976-88030030; ugbllc@gmail.com
Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Д.Ариунболд; 976-99998819; Ariunboldkl@gmail.com
Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ Дугаар Хүчинтэй хугацаа	Ашигт малтмал ашиглах (Улаан хас) MV-021252 2048.12.28 дуустал
Галын дүгнэлт	Нийт 2 объект дээр галын дүгнэлттэй 1. Ажилчдын хотхон 2. Засварын цех, түр байрлал бүхий ШТС
Орон нутагтай газар эзэмшлийн тухай хийсэн гэрээний огноо, баталсан хуулийн этгээдийн нэр, албан тушаал, байгууллага	Дугаар: Нийт 6 газар эзэмших гэрчилгээтэй Бүгд 2022 онд шинээр олгогдсон болно
Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	Ерөнхий үнэлгээ баталсан огноо: 2020.10.23 өдөр БОАЖЯ баталсан.
Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	БОННУ-ний тайлан 2021 онд хийгдсэн, Гүйцэтгэгч байгууллага нь: Байгаль орчны зөвлөх үйлчилгээ, судалгаа, үнэлгээний “Саблайм” ХХК
Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	2025.06.25 (Ус ашиглах дүгнэлт)
Төслийн нэр	“Гүн” нэртэй Улаан хас чулууны уурхай
Төслийн харъяаллын байршил	Бага Овоо баг, Гурвантэс сум, Өмнөговь аймаг
Төслийн ангилал	Хас чулуу олборлолт
Төсөл эхэлсэн огноо	2021 он
Төсөл хэрэгжих хугацаа	2048 он хүртэл
ТЭЗҮ баталсан огноо	2019 он (шинэчилсэн ТЭЗҮ)
Энэ оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	Хуулсан хөрс: 26 мян тонн Олборлосон Хас: 188 тонн
Тайланд туссан тоо, мэдээ	2025.10.31-ны байдлаар тоон мэдээг таслав.

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчны бүрэлдхүүн	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажил	Биелэлт хувь	Гүйцэтгэлийн тайлбар
1	Агаар	Тоосжилт үүсэх (хөрс хуулалт, хас олборлох, хаягдал хөрсийг)	Уурхайн карьер доторх замд хайрга чулуу дэвсэх, хуурайшилттай үед усалж байх	100%	Бид уурхайн ашиглалтын улмаас үүсэх тоосыг дарах зорилгоор 1 техникээр худгийн уснаас 10-р сарын 31-ний өдрийн байдлаар нийт 801 м³ ус авч ашигласан байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН-2025 ОН



		овоолох, асгах, тээвэрлэх) болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах	100%	Уурхайд ашиглагдаж буй хөдөлгөөнт техник 5000 км/цаг, суурийн техникүүдийг 250 мот/цаг ажлуулаад бүрэн засвар үйлчилгээнд оруулж тос маслыг сольдог. Энэ нь агаарт ялгарах хорт хий, утааг стандарт хэмжээнд байлгах үндэс юм.
			Дизель түлш ашигладаг дотоод шаталт хөдөлгүүрүүд болон машинуудыг ашиглаагүй үед сул асаалттай байлгахгүй байх, шаардлага хангахгүй байгааг нь шинэчлэх	100%	Дизель түлш ашигладаг дотоод шаталт хөдөлгүүрүүд болон машинуудыг ашиглаагүй үед сул асаалттай байлгахгүй байх талаар нийт операторуудад сургалт орж танилцуулсан ба үйл ажиллагаа явуулах хугацаанд мөрдөж ажилласан. Сургалтын гарын авлагад туссан материалаар нотлогдох ба нийт 42 ажилтан тус зааварчилгаатай танилцаж гарын үсэг зурсан баталгаа байгаа. Техникуудийг цаг тухайд нь бүрэн засвар үйлчилгээнд оруулж тос маслыг сольдог бөгөөд улсын үзлэгт хамруулахад шаардлага хангахгүй техникүүд байгаагүй болно.
2	Гадаргын болон гүний ус	Ус ашиглах, Ахуйн хаягдал, шатах, тослох материал ба бусад хаягдлаас бага гүний уст давхарга болон хөрс ургамал бохирдох	Хамгаалалтын бүс тогтоож ажиллах,	100%	Хамгаалалтын бүс тогтоож ажилласан <i>Хавсралтаас хамгаалалтын бүс тогтоолгосон захирамж болон тоолуурын баталгааны хуудсын хуулбарыг харж болно.</i>
			Ус ашиглах дүгнэлтэд зааснаас өөр зориулалтаар ус ашиглах, бусдад худалдан борлуулах, усны төлбөр хураамж төлөхгүй байх зэрэг усны тухай хууль тогтоомж зөрчихгүй байх	100%	Ус ашиглах дүгнэлтэд зааснаас өөр зориулалтаар ус ашиглаагүй ба бусдад худалдан борлуулах, усны төлбөр хураамж төлөхгүй байх зэрэг усны тухай хууль тогтоомж зөрчөөгүй. Уурхайн худгийн уснаас 801 м3 ус ашигласан ба нийт ноогдох төлбөрийг дүгнэлтэд зааснаар төлөөд байна.



3	Хөрс, ургамлан бүрхэвч	Хөрс элэгдэл эвдрэлд орж үржил шим, чийг буурах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Уурхайн дотоод тээвэрлэлтийн замыг хайрган хучилттай болгох, гадаад тээврийн 1.2 км замыг мөн хайрган хучилттай болгох	100%	Уурхайн дотоод тээвэрлэлтийн замыг хайрган хучилттай болгосон ба гадаад тээврийн 1,2 орчим метр замыг мөн хайрган хучилттай болгов. Хавсралт зургаас харж болно.
		Тээвэрлэлтийн улмаас хөрсний эвдрэл үүсэх	Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах,	100%	Уурхайн замын хөдөлгөөний дотоод журмаар хөдөлгөөнт техникийн хурдны хязгаарлалт 60км/цаг хэтрэхгүй байхаар зохицуулсан бөгөөд уурхайн идэвхтэй бүсэд 40 км/цаг хурдтай явах журам батлагдан тэмдэг тэмдэглэгээ байршуулсан.
		Ахуйн хаягдал, шатах, тослох материал алдагдах, шигшүүрийн хаягдлыг зайлуулах үед хөрс бохирдох	Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх,	100%	Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдлыг зориулалтын саванд хийлгэх болон шатах тослох материалын хадгалалт ашиглалтанд тогтмол хяналт тавьж ажилласан. Бид байгаль орчны дотоод үзлэг шалгалтаар илэрсэн үл тохирлыг тухай бүрд нь цэвэрлүүлсэн.
			Шатахуун түгээх түр станци, агуулах болон засварын төвийн талбайг хатуу хучилттай болгож газрын гадарга, хөрс бохирдохоос сэргийлэх	100%	Шатахуун түгээх түр станци, агуулах болон засварын төвийн талбайг хатуу хучилттай болгож газрын гадарга, хөрс бохирдохоос сэргийлсэн. Фото зураг харах
			Хог хаягдлыг тухай бүрт нь ангилан зайлуулах арга хэмжээ авах	100%	Хог хаягдлыг тухай бүрт нь ангилан зайлуулах арга хэмжээ авсан ба хог хаягдлыг зохистойгоор хаяж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажлын байрны шалгалт тогтмол явуулсан. Асгаралттай тэмцэх иж бүрдэл бүхий цэг уурхайн хэмжээнд 2 байдаг бөгөөд холбогдох хэлтсүүд сайжруулах арга хэмжээ авч ажилласан.

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.8 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлыг хүрээнд Өмнөговь аймгийн Байгаль орчны газраас өгсөн чиглэлийн дагуу ашигт

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН-2025 ОН



малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нөхөн сэргээлтийн хүрээнд эвдэрч эзэнгүй орхигдсон тодорхой газар нутгийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулж Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын нутаг болох “Ховхон” нэртэй газрын зүүн урд 2 га газрыг техникийн нөхөн сэргээлт хийж суманд хүлээлгэж өгөв.





4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11 -д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг.

Сүүлийн жилүүдэд Монгол улсад уул уурхай, түүнийг дагасан дэд бүтэц, бусад бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүд эрчимтэй хөгжихийн хирээр биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөлөл нэмэгдсээр байна. Нөлөөллийг бууруулах дарааллыг зохистой хэрэгжүүлэх, олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас холбогдох эрх зүйн орчныг бий болгон ажиллаж аж ахуйн нэгж байгууллагууд түүнийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Өмнийн говийн баялаг” ХХК нь Гүнгийн уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байхаар төлөвлөн хамгааллын ажлыг шат дараатай хэрэгжүүлж байна. Үүний нэг нь биологийн олон янз байдлын амьдрах орчинг тэтгэх, тэдгээрийн үйлчилгээг дэмжих, судалгаа шинжилгээний ажилд үндэслэн хамгааллын менежментийн ажлыг зохион байгуулах ажил юм.

Төслийн үйл ажиллагаа явуулж буй цөл, цөлөрхөг хээрийн бүс нутаг нь эрс тэс уур амьсгалтай, эмзэг экосистемд тооцогддог. Экосистемийг бүрдүүлж буй биологийн олон янз байдлын зүйл дотор олон улс болон бүс нутгийн хэмжээнд ховор, ховордож болзошгүй, мөн популяцийн төлөв байдлын мэдээлэл

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН-2025 ОН



дутмаг амьтан, ургамал олон бөгөөд тэдгээрийг хамгаалах, сөрөг нөлөөлөлд өртүүлэхгүй байлгах нь компаний байгаль орчны бодлогын нэг хэсэг юм.

Манай компани 2025 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Тост, Тосон Бумбын нурууны байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаа болон Майтеч ХХК-тай хамтран Тостын нурууны биологийн олон янз байдлыг хамгаалахад мэдээллийн төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, ингэснээр байгаль хамгаалах ажилд мэдээлэл сурталчилгаа, экологийн боловсрол хүмүүжил олгох чиглэлээр хувь нэмэр оруулж ажилласан.

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тухайн төслийн уурхайлалтын болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй. Б.Баттөрийн асуудлыг Гурвантэс сумын ЗДТГ -тай хамтран шийдвэрлэсэн ба 50 сая төгрөг олгож нөхөн олговор өгөв. Харин нөлөөллийн бүсэд байрлах 2 өрхөд өвөлжилтийн бэлтгэл хангахтай холбоотой өвс, тэжээлийн хандив тус тус 4,5 сая төгрөгийн тусламж үзүүлэв.

 **ХААН БАНК**

Огноо/Date: 2025-05-06 12:11:28

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын /Journal No: 16211581

Системийн огноо/System Date: 2025-05-06 12:11:23

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5628295994	ӨМНИЙН ГОВИЙН БАЯЛАГ	2,000,000.00 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No 050000 IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number 5589014891	Банкны нэр/Bank Name ХААН БАНК Нэр/Name НОЁН ДЭЧИН СИЙЛЭГБАЗАР	2,000,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:
ЕВ-Өвс тэжээлийн дэмжлэг

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers



ХААН БАНК

Огноо/Date: **2025-07-02 10:33:27**

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
 Журналын /Journal No: **7983715**

Системийн огноо/System Date: **2025-07-02 10:33:22**

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5628295994	ӨМНИЙН ГОВИЙН БАЯЛАГ	1,500,000.00 MNT	1.00

Кт	Банкны дугаар/Branch No 050000	Банкны нэр/Bank Name ХААН БАНК		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name	1,500,000.00 MNT	1.00
	5589014891	НОЁН ДЭЧИН СИЙЛЭГБАЗАР		

Гүйлгээний утга/Transaction description:
ЕВ-Өвс тэжээлийн дэмжлэг

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Мөн тухайн 2 өрхийн хамааралтай 3 иргэнийг ажилд авч тогтвортой ажлын байраар хангаж нийт 40 сая гаруй төгрөгийн цалин олгосон.

Овог нэр	Регистр	Ямар албан тушаалд
Б.Баяржаргал	КГ99060913	Уулын туслах
Д.Дагвасүрэн	КГ73012330	Автосамосвалын оператор
Д.Наранбадрах	КГ93083014	Автосамосвалын оператор

6.ТҮҮХ, СОЁЛЫГ ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Биет бус өв соёлыг хамгаалахад доорх 2 чиглэлээр орон нутагт дэмжлэг үзүүлж ажилласан.

- Эрийн гурван наадмыг санхүүжүүлэх
- Улсын түвшний том хэмжээний сурын харвааг дэмжих

Өмнөговь аймгийн Гурвантэс сум газар нутгийн хэмжээгээр улсын хамгийн том газар нутагтай сум төдийгүй газар газрын 600 гаруй харваачид цуглаж тус газар нутгийн онцлог, өвөрмөц дүр төрх, байгалийн сайханыг шимтэн харж сэтгэл, оюун бодол, цэц мэргэнээ сорьж 3 хоног өрсөлдөн зэрэг, цол авч мөн ирээдүй хойч үедээ сурын харвааг өвлүүлэн үлдээх, бусдад сурталчилах сайхан ажлыг манай байгууллага нийт 20 сая төгрөгөөр ивээн тэтгэж ажилласан нь түүх соёлын биет бус өвийг хамгаалахад үнэтэй хувь нэмэр оруулж ажилласан.

Бага-Овоо багийн иргэдийг Эрийн 3 наадмаа өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлэх, түүх соёлоо уламжлан авч үлдэх үйлсэд хувь нэмэр оруулж 2.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж наадмын бай шагналыг дааж ажилласан. Манай байгууллагын хувь орон нутгийн компани тул орон нутгийн иргэд, тэдний сайн сайхан байдлын төлөө чамгүй хөрөнгө зарж, нээлттэй ил тод үйл ажиллагаагаа эрхлэн явуулахыг зорьдог тул орон нутагтай нягт хамтран ажилладагаараа давуу талтай юм. Ийм ч учираас орон нутгаас ирсэн, өргөдөл, санал, хүсэлтийг цаг тухайд нь хүлээн авч биелүүлэн ажилладаг.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН-2025 ОН



Огноо/Date: 2025-06-09 13:57:26

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын /Journal No: 22278805

Системийн огноо/System Date: 2025-06-09 13:57:21

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5628295994	ӨМНИЙН ГОВИЙН БАЯЛАГ	20,000,000.00 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No 050000	Банкны нэр/Bank Name ХААН БАНК		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name	20,000,000.00 MNT	1.00
	5589198005	ӨМНӨГОВЬ АЙМАГ ГУРВАНТЭС СУМЫН ГУРВАН ТЭГШИЙН МЭРГЭД ҮНДЭСНИ		

Гүйлгээний утга/Transaction description:
ЕВ-Өмнийн говийн баялаг ХХК сур харваад

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
БАГА-ОВОО БАГИЙН ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон 100 тоот, Бага-Овоо баг,
Гурвантэс сум, Өмнөговь аймаг, 46155,
Утас: (976) 7053 6019
Цахим шуудан: gurvantes_zdtg@yahoo.com

2025.07.25 № 74

танай _____-ны № _____-т

“ӨМНИЙН ГОВИЙН БАЯЛАГ” ХХК-д

Танай “Өмнийн говийн баялаг” ХХК нь Бага-Овоо багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд багийн үйл ажиллагааг тогтмол дэмжиж ажилладаг талархал илэрхийлье.

2025 оны 08 дугаар сарын 05 ны өдөр багийн өдөрлөг, баяр наадмын үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Иймд танай компанийг “Баяр наадам” ын үйл ажиллагаанд хэрэглэгдэх 300 литр айраг цэгээний зардал болох 2,5 сая төгрөгийг шийдвэрлэхэд дэмжиж, хамтран ажиллахыг хүсье.



ЗАСАГ ДАРГА

Б.ЭРДЭНЭБААТАР



7.ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Биелэлт хувь	Гүйцэтгэлийн тайлбар
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	100%	Өглөө бүр нариад өгч нийт ажилчдад ААЗааварчилгаанд гарын үсэг зуруулж ажилд гарна
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	100%	Нийт 51 ажилтанд сургалт орж гамшигаас урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний талаар мэдлэг мэдээлэл өгсөн.
	Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах,	100%	Гал унтраах хэрэгслээр бүрэн хангаж арга хэмжээ авч ажилласан.
	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	100%	Гэнэтийн ослын үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлсэн
Хүний эрүүл мэндэд нөлөөлөл үүсэх	Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангах	100%	Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр хангаж ажилласан ба орон нутгийн аж ахуйн нэгжээр 9 орчим сая төгрөгийн ажилчдын хувцас оёуулсан.

8.ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Биелэлт хувь	Гүйцэтгэлийн тайлбар
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйг ээс орчин бохирдох	Хог хаягдлыг төрөл тус бүрээр ангилан ялгах, түр хадгалах, цэгийг хашаа хамгаалалтаар тохижуулах	100%	Хог хаягдлыг төрөл тус бүрээр ангилан ялгаж, түр хадгалах, хогийн цэгийг хашаа хамгаалалтаар тохижуулсан.
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, ШТС, зогсоол зэрэг газарт байрлуулах	100%	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийж, ажилчдын байр, агуулах, ШТС, зогсоол зэрэг газарт байрлуулсан
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	100%	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах түүний эд авдаг газарт өгч 300 гаруй мянган төгрөгийн мөнгөн сан үүсгэж БО хамгаалахад зарцуулсан.
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх	100%	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж УБ тээвэрлүүлэн хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрт нийт 4 тонн хаягдал нийлүүлсэн
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын	100%	Нийт 58 ажилтанд сургалт орж Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар мэдлэг мэдээлэл өгсөн.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН-2025 ОН



Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Биелэлт хувь	Гүйцэтгэлийн тайлбар
	мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх		
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулах	100%	Бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулах ажил 100% тай явагдаж ашиглалтанд орсон байна.
Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах	100%	Дизель түлш ашигладаг дотоод шаталт хөдөлгүүрүүд болон машинуудыг ашиглаагүй үед сул асаалттай байлгахгүй байх талаар нийт операторуудад сургалт орж танилцуулсан ба үйл ажиллагаа явуулах хугацаанд мөрдөж ажилласан

9.ОРЧНЫ ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээ хийх ажлыг мэргэжлийн байгууллага болох “ТОДБАТ” ХХК-иар гүйцэтгүүлсэн.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хаана	Биелэлт хувь	Гүйцэтгэлийн тайлбар
Агаарын чанар				
1.1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Уурхайлалт явагдаж буй талбайд	100%	Шинжилгээний дүгээс харахад агаар дахь азотын давхар ислийн агууламж MNS4585:2016 стандартад заагдсан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан цэг байхгүй байна. Хэмжилт хийсэн 4 цэгээс түр кемп орчмын цэгт бусад цэгээс өндөр гарсан боловч MNS 4585:2016-д заагдсан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байна ОХШХ-ийн тайлангаас харах
1.2	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Уурхайн үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах	100%	Шинжилгээний дүгээс харахад агаар дахь тоосны агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна. Тоосны агууламж хамгийн өндөр хэмжигдсэн цэгт 0.071 мг/м ³ байгаа нь MNS 4585:2016 стандартад заагдсан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 7 дахин бага байна. ОХШХ-ийн тайлангаас харах



№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хаана	Биелэлт хувь	Гүйцэтгэлийн тайлбар	
1.3	Дуу шуугиан, чичиргээ:	Машин механизмын ажиллагаа, хөдөлгөөнөөр шуугиан үүсэх	100%	Хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, экосистемийн тэнцлийг хангах зорилгоор хүрээлэн байгаа агаар болон аливаа орон байрны доторх орчны агаар дахь дуу шуугиан, чичиргээний хүлцэх хэм хэмжээг тогтоосон стандартын үзүүлэлттэй сорилтын дүнг харьцуулахад хүлцэх агууламж нь сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй. ОХШХ-ийн тайлангаас харах	
Хөрсний бохирдол					
2.1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент,хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Төслийн талбайд 4 цэг сонгох Уурхайн суурин, хөрсний овоолго орчим болон олборлолтод өртөөгүй цэг, уурхайн талбайд	100%	Элсэнцэр болон элсэн механик бүрэлдэхүүнтэй хөрс нь ус чийг тогтоон барих чадвар муутай, ургамалд хялбар ашиглагдах үржил шимээр ядмаг байдаг. Мониторингийн бүх цэгүүд элсэнцэр, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна.	Давсжилт ихтэй хөрсөнд зөвхөн давссаг ургамал ургахад тохиромжтой байдаг. Судалгааны үр дүнгээс харахад ЕС _{1:2.5} -ийн утгын хэлбэлзэл 0.011-0.716 dS/m хооронд байна. Бүх цэгүүдэд ЕС _{1:2.5} -ийн утга 0.77dS/m-ээс доош буюу сулаас дунд зэрэг давсархаг байна. Мониторинг цэгүүд дэх хөрсний Хромын агууламж стандартын хүлцэх агууламж 150 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна.
	Хүнд металлын агууламж	Дээрх 4 цэгт	100%	Хөрсний хүнд металл гэдэг нь нягт нь 5 г/см ³ –ээс илүү, атом масс нь 40-өөс илүү, хөрсөнд тогтвортой удаан хугацаагаар хадгалагддаг, амьд организмд аюултай хор нөлөө үзүүлдэг, уусах чанар багатай, удаан задардаг био-идэвхт, хортой, онцгой хортой элементүүд юм	Мониторинг цэгүүд дэх хөрсний Хартугалгын агууламж стандартын хүлцэх агууламж 100 мг/кг-аас хэтрээгүй бага хэмжээнд байна



№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хаана	Биелэлт хувь	Гүйцэтгэлийн тайлбар
Усны хяналт шинжилгээ				
3.1	Усны чанар pH, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий шинжилгээ	Төслийн талбай орчим	100%	Унд ахуйн усны чанарыг тодорхойлох зорилгоор мониторингийн цэгийн дагуу дээжлэлт хийж химийн шинжилгээний үзүүлэлтүүдийг тодорхойлуулж Монгол улсын ундны усны стандарт MNS 900:2018-тай харьцуулав. Унд ахуйн усны худгийн усны шинжилсэн үзүүлэлтүүд нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартын шаардлагыг хангаж байна. Газрын доорх усны физик үзүүлэлтээс харахад усны тунгалаг нь 30 см-ээс их, үнэргүй, өнгөгүй, булингаршлын хувьд 0.56 NTU байна
Ургамлын аймаг				
4.1	Ургамал устах, өсөлт ургалт нь саатах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц, биомасс багасах	Төсөл хэрэгжиж буй талбай болон түүний ойр орчим 2 цэгт	100%	Ургамлын мониторингийн 2 цэгт ургамлын бичиглэлийг хийв. Төслийн талбайн гол зонхилогчоор бариулт бүйлээс <i>Amygdalus pedunculata</i> , орог тэсэг <i>Eurotia ceratoides</i> , <i>өргөст ортууз</i> <i>Oxytropis aciphylla</i> , таана <i>Allium polyrrhizum</i> , хөмөл <i>A. Mongolicum</i> . Rge, хуурайсаг шарилж <i>A. xerophytica</i> , алтан харгана <i>Aragana leucophloea</i> , бунгийн харгана <i>Caragana bungei</i> , Ямаан ангалзуур <i>Lagochilus ilicifolius</i> , улаан бударгана <i>Reuamuria soongorica</i> , бор бударгана <i>Salsola passerina</i> , хулан хойрго <i>Potaninia mongolica</i> , зээргэнэ <i>Ephedra przewalskii</i> , хөмүүл <i>Allium mongolica</i> , зэрэг ургамлуудыг дурдаж болохоор байна

10. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Өмнөговь аймгийн Байгаль орчны газрын хяналт шалтгалт хариуцсан хэлтсийн даргаар ахлуулсан ажлыг хэсэг 2025 оны 4 дүгээр сард удирдамжийн дагуу нийт 6 чиглэлээр хяналт, шалгалт хийж манай байгууллагын хувьд зөрчил дутагдалгүй ажилласан.

Энэ нь уурхайн үйл ажиллагаа дундаа зогсолттой бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй байсан ба үйл ажиллагааны цар хүрээ ч хумигдмал байсан нь нөлөөлсөн.



11.БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлэгч “Өмнийн говийн баялаг” ХХК Монгол Улсын байгаль орчинтой холбоотой хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байлгах, нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, дүйцүүлэх хамгаалах, төсөл хэрэгжих орчинд бий болох болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг тогтмол хянаж, илрүүлэх, хариу арга хэмжээ авах, орон нутгийн иргэдийн оролцоотой байгаль орчныг хамгаалж, уг үйл ажиллагаанд манлайлагч байх зорилгоо биелүүлж ажилласан гэж дүгнэж байна.

Бид 2025 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 70,340,000 төгрөг зарцуулан Компанийн гүйцэтгэх удирдлага, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Байгаль орчны хэсэг, Байгаль орчны мэргэжилтэн, шаардлагатай үед тусгай эрх шаардсан байгаль орчны мэргэжлийн байгууллага гэсэн удирдлага зохион байгуулалтын бүтэцтэйгээр ажиллав.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт хувь	Гүйцэтгэлийн тайлбар
1	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулах	100%	2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж системээр батлуулсан
2	Тоорой модны үр түүх, 50 доошгүйг бортогонд бойжуулах	100%	Тоорой модны үр түүж нийт 150 ширхэг бортогонд бойжуулах ажил хийв
3	Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдийг сургуулийн хүүхдүүд болон иргэдийн экологийн боловсролыг дэмжих үүднээс зохион байгуулах	100%	Өмнөговь аймгийн Байгаль орчны газраас “Дэлхийн усны өдөр”-т зориулан хүүхэд багачуудын дунд Ширээний теннисний тэмцээн зохион байгуулсан ба уг арга хэмжээнд 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллав
4	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хамтарсан багийн ажлыг дэмжих, хамтран ажиллах	100%	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хамтарсан багийн ажлыг дэмжих, хамтран ажиллах ба 3,200,000 төгрөг Өмнөговь байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн
5	Ус ашиглах дүгнэлт гаргуулах, Ус ашиглах гэрээг холбогдох төрийн байгууллагатай хийх	100%	Ус ашиглах дүгнэлт гаргуулсан, гэрээ хийж дүгнэлтээр төлбөр төлөв.
6	Уурхайд ашиглагдаж буй бүх усны эх үүсвэрүүдээс дээж авч шинжилгээнд явуулах, чанарт хяналт тавина	100%	Уурхайд ашиглагдаж буй бүх усны эх үүсвэрүүдээс дээж авч шинжилгээнд явуулсан
7	Тоосыг эх үүсвэр дээр нь дарах арга хэмжээг авч тогтмол усалгааг хийх	100%	Тоосыг эх үүсвэр дээр нь дарах арга хэмжээг авч тогтмол усалгааг хийсэн
8	“Тэрбум мод” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2500 ширхэг мод худалдан авч тарих ба дотоод үйл ажиллагааны зардлаас гаргана	100%	“Тэрбум мод” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2500 ширхэг бургас Сэврэй сум Хонгорын элсэнд тарьсан маш амжилттай ургасан ба нийт ургалтын хувь 93%-тай
9	Нийт ажилчдад уурхайн хог хаягдлын талаар сургалт зохион байгуулах	100%	Нийт 58 ажилтанд уурхайн хог хаягдлын талаар сургалт зохион байгуулсан
10	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан мэдээ боловсруулах	100%	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан мэдээ боловсруулсан

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН-2025 ОН



12.БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРИЙН БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлэгч “Өмнийн говийн баялаг” ХХК жил бүр БОМТ -ний хэрэгжилтийн талаарх тайлангаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 дугаар тушаалын “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 4.1 дэх заалтын дагуу Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлж ажилласан ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, Гурвантэс сумын Засаг дарга зэрэг албаны хүмүүст хүргүүлэв.

Төсөл хэрэгжүүлэгч нь нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн нийтийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг 11 сардаа багтаан хийнэ.

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Гүйцэтгэлийн тайлбар
Сум, багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг	11-р сар	11 дүгээр сарын сүүлээр Бага овоо багийн ИНХуралд танилцуулахаар тов авсан
БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тухайн жилийн БОМТ , тайлан	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12 -р сар	Аймгийн ажлын хэсэг дүгнэсэн актын хамт хүргүүлэх



ХАВСРАЛТ



Өмнөговь аймгийн Байгаль орчны газраас “Дэлхийн усны өдөр”-т зориулан хүүхэд багачуудын дунд Ширээний теннисний тэмцээн зохион байгуулсан ба уг арга хэмжээнд 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллав.



БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН-2025 ОН



Гүйлгээ амжилттай.

3,000,000.00 MNT

2025/04/04 18:23

Дансны үлдэгдэл



Хүлээн авагч

ЦЭРЭНДУЛАМ ЖАРГАЛСАЙХАН
MN77 0030 00 3055052237



Гүйлгээний утга

Өмнийн говийн баялаг ХХК 3623955
усны өдөрт



Уурхайн худгийн тоолуурын зураг 2025



Уурхайн дотоод замын зураг 2025

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН-2025 ОН



“Тэрбум мод” ажлын хүрээнд Өмнөговь аймгийн БОАЖГазраас заасан газар болох Гурвантэс сумын Дундгол гэх нэртэй газарт мод тарих 200 метр газар хашаажуулж ажиллалаа. 2025 оны 09 дүгээр сар
Төсөв: 4.5 сая

